

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Зээлийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Зээлдэгчдийн банкнаас авсан зээлийн хэмжээ					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Зээлдэгч нь амь насаа алдсан; 2. Зээлдэгч нь хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан, 3. Зээлдэгч нь ажлаас халагдсан; 4. Зээлдэгч орон тооны цомхтголд орсон; 5. Зээлдэгчийн ажил олгогч байгууллага нь татан буугдсан;					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.5%-1.2%					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ:

- Дараах **тохиолдолд** даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:
 - Худалдан авагчийн харьяалагдах улсад тохиосон хар салхи, үер, газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, далайн том давалгаан болон байгалийн гамшгийн бусад үзэгдлээс үүдсэн хохирол;
 - Цөмийн түлш, түүний хог хаягдал, шаталтаас үүсэх тэсрэх бодис, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ионжуулагч, цацраг идэвхт, хорт, тэсрэх бодисын болон бусад аюултай, бохирдуулагч шинж чанар, нөлөөллөөс шууд болон шууд бусаар үүдсэн хохирол;
 - Их таван улс буюу “БНХАУ, АНУ, ОХУ, Франц болон Нэгдсэн вант улс” эдгээрийн хоорондын дайн байлдаанаас үүдсэн хохирол
 - Худалдан авагч ямар нэгэн шалтгаанаар төлбөрийг хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр суутгах, гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэлтэй гэж мэдэгдэж байгаа маргааны улмаас үүдсэн хохирол. Уг маргааныг шүүхийн эцсийн шийдвэр эсвэл Арбитрын эцсийн шийдвэрээр даатгуулагчийн талд нааштайгаар шийдсэн тохиолдолд даатгалын хасалтад оруулахгүй.

- 1.5. Даатгуулагч эсвэл даатгуулагчийг төлөөлж буй эсвэл даатгуулагчийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг аливаа этгээд гэрээний аль нэг нөхцөл, болзлыг биелүүлээгүй, эсвэл аливаа хууль тогтоомж, тушаал, шийдвэр, тогтоол, журмын заалтыг дагаж мөрдөөгүйгээс үүдсэн хохирол.
 - 1.6. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай импортын болон экспортын тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрөл аваагүйгээс үүссэн, эсвэл гэрээний гүйцэтгэл нь валютын хяналтын аливаа зохицуулалттай зөрчилдсөнөөс үүдсэн хохирол. Уг хасалт нь даатгалын хамгаалалт эхэлсэн өдрөөс хойш зайлшгүй байдлаар үүссэн эсвэл валютын хяналтын журам хүчин төгөлдөр болсон тохиолдолд үйлчлэхгүй.
 - 1.7. Даатгагч болон даатгуулагч бичгээр тохиролцоогүй бол барааг илгээх, үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх эсвэл худалдан авагчийн улсаас бусад орноос төлбөр хийхтэй холбоотойгоор гуравдагч орноос үүдсэн хохирлыг хасалтанд оруулна.
2. **Авлагатай холбоотой дараах хохирлын** хувьд даатгалын хамгаалалт үйлчлэхгүй. Үүнд:
- 2.1. Цэргийн болон цэргийн зориулалттай эсвэл авлигын шинжтэй үйл ажиллагаа эсвэл даатгуулагч болон даатгуулагчийн төлөөлөгч, даатгуулагчийн томилсон этгээдтэй хамааралтай мөнгө угаах гэмт хэрэг, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлсэн бараа, ажил үйлчилгээ, худалдааны авлага.
 - 2.2. НҮБ-ын аливаа шийдвэр, олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн аливаа улс орон, олон улсын байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эсвэл аливаа худалдаа, эдийн засгийн хоригийн дагуу даатгагч болон олон улсын давхар даатгагчдад тавигдсан аливаа хориг арга хэмжээ, хориг, хязгаарлалт үйлчлэх бараа, үйлчилгээ, худалдааны авлага.
 - 2.3. Төлбөр төлөх хугацаа дууссанаас хойш хуримтлагдсан аливаа хүү.
 - 2.4. Худалдан авагчаас төлөх өр төлбөрөөс гадна гэрээний дагуу эсвэл өөр хэлбэрээр ногдуулсан, нэмж төлөх торгууль, хохирол.
 - 2.5. Гэрээний дагуу худалдан авагчаас авах ёстой төлбөрийн нэг хэсэг байхаар тохиролцоогүй банкны аливаа зардал.
 - 2.6. Даатгуулагч худалдан авагчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх эсвэл даатгуулагчийн эсрэг үүсгэсэн эсвэл даатгуулагчийн санаачилсан аливаа хэргийг өмгөөлөхөд гарах зардал.
 - 2.7. Даатгагч нь даатгуулагчид учирсан хохирол нь түүний эзэмшиж буй аливаа бусад даатгалаар хамгаалагдсан (эсвэл энэхүү гэрээгээр шийдэгдэх нөхцөлтэй) ба тэрхүү даатгалын гэрээгээр нөхөн төлбөр эвсэл төлбөрийг хүлээн авахаар тохиролцсон байх тохиолдолд хариуцлага хүлээхгүй.
 - 2.8. Зээлийн эрсдлийн хамгаалалт эхлэхээс өмнө дансандаа хүлээн авсан авлага (cleared fund)-д уг даатгал хамаарахгүй.
 - 2.9. Уг даатгал нь бараа, үйлчилгээг хүргэсэн даруйд төлбөрийг төлөх нөхцөлд хамаарахгүй.
 - 2.10. Даатгалын гэрээнд хамааралгүй өмнөх зээлийн шугам, авлагатай холбоотой аливаа хохирол;
 - 2.11. Даатгалын хамгаалалтанд нэмэгдсэн өртгийн албан татвар, түүнтэй харьцуулж болох аливаа эргэлтийн татвар, төлбөр хамаарахгүй.
3. Бичгээр өөрөөр тохиролцоогүй бол хасалтанд орсон авлагатай холбоотой эсэхээс үл хамааран хүлээн авсан бүх төлбөрийг уг даатгалын төлбөрийн хуваарилалтын нөхцөлийн дагуу хуваарилна.
4. Дараах худалдан авагчдаас авах авлагад уг даатгал үйлчлэхгүй. Үүнд:
- 4.1. Бичгээр өөрөөр тохиролцоогүй бол даатгуулагчийн шууд болон дам байдлаар хяналт тавьж байгаа эсвэл шууд болон шууд бус ашиг сонирхол бүхий эсвэл даатгуулагчид хяналт тавьж байгаа худалдан авагчдын төлөх төлбөрийг даатгахгүй.
 - 4.2. Энэхүү даатгал нь арилжааны үйл ажиллагаа эрхэлдэггүй хувь хүнд төлөх аливаа өр төлбөрийг даатгахгүй.